



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 5 сарын 30 өдөр

Дугаар А/423

Булган сум

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг
түр хязгаарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.15, 66 дугаар зүйлийн 66.1, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Захиргааны ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдөр Булган сумын Засаг даргын Тамгын газрын баруун талын дөрвөн замын уулзвараас Онцгой байдлын газрын зүүн талын гурван замын уулзвараар дамжин зүүн дөрвөн замын уулзварыг 09.00-20.00 цагийн хооронд, Баруун дөрвөн замаас "Олл март" худалдааны төвийн зүүн урд талын гурван замын уулзварыг 09.00-15.00 цагийн хооронд тус тус тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарласугай.

2. Дээрх хугацаанд хөдөлгөөний аюулгүй байдал хэв журмыг хангаж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Л.Ганбаатар)-т, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба (Т.Алтанцэцэг)-нд тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-т даалгасугай

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6323010416